



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/372

Есөнбулаг

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.7, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Алтай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг тайлагнах зорилгоор хийгдэж буй видео, нэвтрүүлэг, гэрэл зургийг мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэх ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т шилжүүлж, зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 10.000.000 (арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын
2024 оны 04 дугаар сарын 22 -ны
өдрийн 01 дугаар захирамжийн
хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭНЧИГЛЭЛ, ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН ВИДЕО,
НЭВТРҮҮЛЭГ, ГЭРЭЛ ЗУРАГ

№	Төсөл арга хэмжээний нэр	Эрх шилжүүлсэн байгууллага	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг
1.	Говь-Алтай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан таниулах, хэрэгжилтийг тайлагнах зорилгоор хийгдэж буй видео, нэвтрүүлэг, гэрэл зургийг мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэх ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх	АЗДТГ	2024.04	2024.07	
Нийт дүн					10.000.000

__оОо__



 ...

(1. ...)

2. ...

3. ...

4. ...

5. ...

6. ...

7. ...

8. ...

9. ...

10. ...

...

...

...

...



...